

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөө аж ахуйг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2023/17//НА-СТА-ЗГТС

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2023 он</p>	<p>Санхүү нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Г.Гүнжидмаа Утас: 261685 Цахим хаяг: Gunjidmaag@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Болор-Эрдэнэ Утас: 261740 Цахим хаяг: Bolor-Erdened@audit.gov.mn Аудитор: П.Амарсанаа Утас: 261740 Цахим хаяг: Amarsanaap@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨДӨӨ АЖ АХУЙГ ДЭМЖИХ
САНГИЙН ДАРГА Б.ЦОГТСАРАН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2023 03.24 № 01/678

танай _____-ны № _____-т

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөдөө аж ахуйг дэмжих сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас Хөдөө аж ахуйг дэмжих сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илрүүлсэн дараах зөрчлүүд санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө материаллаг бөгөөд түгээмэл тархсан байна. Үүнд:

- Тайлант онд 9,888 харилцагчийн 179,257.2 сая төгрөгийн авлага, 315 харилцагчийн 67,875.0 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн акт үйлдэж, баталгаажуулаагүй;
- Чанаргүй, хугацаа хэтэрсэн, төлөлт хийгдээгүй 9,045 харилцагчийн 153,801.4 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй;
- Урсгал үйл ажиллагааг санхүүжүүлэх төсөвгүй 15,261.3 сая төгрөгийг зээлийн эргэн төлөлтөөс зарцуулсан;
- Хөдөө аж ахуйг дэмжих сангийн 2022 онд эргэж төлөгдөх цэвэр зээлийн төлөвлөгөөний гүйцэтгэл 7.1 хувь;
- Дамжуулан зээлийн эргэн төлөлтөөс төсөвт төвлөрүүлэх дүнг жил бүрийн төлөвлөгөөнд тусгаагүй, үйл ажиллагааны зардалд зарцуулснаас нийт 52,712.0 сая төгрөгийн зээлийн өр хуримтлагдсан;
- Гэрээнд заасан барьцааны шаардлага хангахгүй 16 иргэн, хуулийн этгээдэд 3,445.3 сая төгрөгийн дэмжлэгийн зээл олгосон, эрсдэлийн үнэлгээ хийхдээ төслүүдийн эдийн засгийн үр ашиг, төлбөрийн чадварын талаар дүгнэлт гаргаагүй;

- Тайлант онд 351.2 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг шууд гэрээ байгуулан, худалдан авалт хийсэн;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин 260.5 сая төгрөгийг хурал, зөвлөгөөн зохион байгуулахад зарцуулсан;
- Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 24 дүгээр зүйлийн 24.1, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5.5, 29 дүгээр зүйлийн 29.5, 31 дүгээр зүйлийн 31.2.1, 31.2.4, 31.2.5, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5, 48 дугаар зүйлийн 48.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6, 15.2.3, Санхүүгийн түрээсийн гэрээний 4 дүгээр зүйлийн 4.2.4, Барьцааны гэрээний 2.2-т заасантай тус тус нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх, тохиолдсон байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасны дагуу тус сан нь үйл ажиллагаа явуулж байгаа боловч "Төрийн өмчит компани байгуулах тухай" Засгийн газрын 2021 оны 394 дүгээр тогтоолын дагуу Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн статустай хуулийн этгээд байхаар улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгосон байна.

Цаашид дээрх төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компаний засаглалд шилжүүлэн ашигтай ажиллах, зах зээлд өрсөлдөж чадахуйц компани байгуулахад сангийн эрх зүйн байдал, хяналтын тогтолцоог оновчтой болгох, Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын хараат бус байдлыг хангах, эрх, үүргийн ялгааг тодорхой болгох, хүний нөөцийн мэргэшсэн тогтвортой байдлыг хангах зэрэг асуудлуудад анхаарах шаардлагатай байна.

Аудитын гол асуудал

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны газар тариалан, мал аж ахуйн салбарыг дэмжих бодлого хэрэгжүүлэх үүрэгтэй сан бөгөөд нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалж төрөөс баримталж буй бодлогын хүрээнд дотоодын гурил, үр тарианы нийлүүлэлтийг тасралтгүй хангах зорилгоор тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуй нэгжид олгосон хөнгөлөлт, урамшууллын зөрүүгээр сангийн санхүүгийн тайлан алдагдал хүлээдэг.

Мөн Хөдөө аж ахуйг дэмжих сангийн 2022 онд эргэж төлөгдөх цэвэр зээлийг 48,036.7 сая төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэлээр Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 1,968.8 сая, Мал хамгаалах сангийн 1,315.2 сая, БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн 139.1 сая, нийт 3,423.1 сая төгрөгийн эргэн төлөлт хийж, 7.1 хувийн гүйцэтгэлтэй.

Иймд сангаас зээл авсан иргэн, хуулийн этгээдийн чанаргүй зээлийг ангилж, түүнд тохирсон эргэн төлөлтийн менежмент хэрэгжүүлж, сангийн санхүүгийн тайлангийн үзүүлэлт, төлбөрийн чадварыг сайжруулах, алдагдлыг нөхөх шаардлага байна.

Бусад асуудлын хэсэг

Хөдөө аж ахуйг дэмжих сангийн орон нутгийн салбаруудад байршиж буй барилга байгууламж, элеваторуудын их засвар, шинэчлэлийн ажил 2013 оноос хойш хийгдээгүй тул элэгдэлд орж ашиглалтын шаардлага бүрэн хангахгүй байгаа нь улсын стратегийн

гол нэрийн бүтээгдэхүүн үрийн буудайн хадгалалт, хамгаалалтад эрсдэл учирч болзошгүй байна.

Тайлант онд 12 зорилтын 32 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 96.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	304,577,075,483.18	301,310,739,696.13
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,477,765,196.04	3,574,931,057.57
31100	Кассад байгаа бэлэн мөнгө	79.87	47,089,000.11
31140	Касс арилжааны банк	79.87	47,089,000.11
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	2,477,765,116.17	3,527,842,057.46
31210	Төгрөг	2,477,765,116.17	3,527,842,057.46
31213	Арилжааны банк дахь харилцах	2,439,912,366.17	3,527,842,057.46
33	АВЛАГА	216,835,794,965.07	219,985,801,544.61
33500	Бусад авлага	20,545,463,730.99	20,453,121,160.08
33510	Байгууллагаас авах авлага	20,404,437,323.70	20,324,547,752.79
33520	Хувь хүмүүсээс авах авлага	141,026,407.29	128,573,407.29
33600	Зээлийн авлага	196,290,331,234.08	199,532,680,384.53
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	196,290,331,234.08	199,532,680,384.53
33615	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	196,290,331,234.08	199,532,680,384.53
35	БАРАА МАТЕРИАЛ	2,313,775,354.35	3,786,014,366.77
35100	Түүхий эд материал	0	147,673,333.40
35110	Тусгай зориулалттай материал	0	147,673,333.40
35300	Бэлэн бүтээгдэхүүн	2,008,416,644.92	2,489,723,816.63
35400	Хангамжийн материал	305,358,709.43	291,639,358.58
35410	Бичиг хэргийн материал	2,316,500.00	1,318,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	296,027,303.73	280,827,858.58
35470	Бусад хангамжийн материал	5,842,105.70	9,493,500.00
35600	Мал амьтад	0	856,977,858.16
36	НӨӨЦИЙН БАРАА	82,949,739,967.72	73,963,992,727.18
36100	Барааны нөөц	343,678,912.00	16,825,000.00
36200	Үрийн нөөц	17,479,372,512.64	11,939,976,555.50
36400	Шатахууны нөөц	10,379,501.77	9,133,708.18
36500	Буудайн нөөц	42,662,009,447.70	54,831,767,053.75
36600	Бусад нөөц	22,454,299,593.61	7,166,290,409.75
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	86,607,839,920.79	83,504,092,828.14
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	86,607,839,920.79	83,504,092,828.14
39200	Биет хөрөнгө	64,197,475,297.31	61,097,948,204.86
39201	Барилга, байгууламж, орон сууц	59,832,322,217.52	59,832,322,217.52
39202	Хуримтлагдсан элэгдэл	-6,422,610,583.45	-8,091,162,186.38
39203	Авто-тээврийн хэрэгсэл	2,768,109,752.00	2,013,477,300.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-1,777,296,617.32	-1,394,993,151.68
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	12,715,421,236.77	12,735,876,832.77
39206	Хуримтлагдсан элэгдэл	-10,134,915,329.71	-11,040,784,427.63
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	382,365,763.40	388,585,763.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-268,631,103.96	-290,771,430.84
39209	Зам, гүүрний байгууламж	4,232,762,503.28	4,232,762,503.28
39210	Хуримтлагдсан элэгдэл	-615,558,669.64	-772,871,344.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,570,217,944.60	2,570,217,944.60
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,570,217,944.60	-2,570,217,944.60
39216	Дуусаагүй барилга, байгууламж	3,485,506,128.42	3,485,506,128.42
39300	Биет бус хөрөнгө	22,410,364,623.48	22,406,144,623.28
39301	Программ хангамж	128,284,000.00	128,284,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-120,828,999.98	-125,049,000.18
39303	Бусад биет бус хөрөнгө	22,402,909,623.46	22,402,909,623.46
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	391,184,915,403.97	384,814,832,524.27
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	311,267,380,801.68	322,948,203,046.06
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	89,789,572,620.33	138,662,987,229.36
41200	Богино хугацаат зээлийн өглөг	11,379,306,319.25	9,982,415,683.25

41210	Төгрөг	10,810,181,747.35	9,494,931,111.35
41211	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	10,810,181,747.35	9,494,931,111.35
41220	Гадаад валют	569,124,571.90	487,484,571.90
41224	Төслийн зээл	569,124,571.90	487,484,571.90
41300	Өглөг	77,690,580,968.08	128,162,749,858.36
41350	Зээлийн хүүгийн өглөг	15,399,971,092.38	18,706,149,659.12
41360	Бусад өглөг	62,267,076,250.32	109,456,600,199.24
41361	Байгууллагад төлөх өглөг	62,227,311,917.42	109,412,934,230.57
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	39,764,332.90	43,665,968.67
41400	Урьдчилж орсон орлого	719,685,333.00	517,821,687.75
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	254,669,346.81	254,669,346.81
41430	Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	22,237,417.00	22,237,417.00
41440	Бусад урьдчилж орсон орлого	414,068,776.19	212,205,130.94
41450	Төрийн өмчийн үйлдвэр, аж ахуйн газар	28,709,793.00	28,709,793.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	221,477,808,181.35	184,285,215,816.70
42200	Урт хугацаат зээл	221,477,808,181.35	184,285,215,816.70
42220	Гадаад валют	221,477,808,181.35	184,285,215,816.70
42224	Төслийн зээл	221,477,808,181.35	184,285,215,816.70
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	79,917,534,602.29	61,866,629,478.21
51	Засгийн газрын хувь оролцоо	79,917,534,602.29	61,866,629,478.21
51100	Засгийн газрын оруулсан капитал	81,130,221,166.51	81,130,221,166.51
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	81,130,221,166.51	81,130,221,166.51
51200	Хуримтлагдсан үр дүн	(14,375,162,386.17)	(32,426,067,510.25)
51210	Өмнөх үеийн үр дүн	10,519,599,194.84	(12,149,898,845.61)
51220	Тайлант үеийн үр дүн	(24,894,761,581.01)	(20,276,168,664.64)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	13,162,475,821.95	13,162,475,821.95
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	391,184,915,403.97	384,814,832,524.27

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9,354,712,602.67	8,513,887,423.53
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,351,112,602.67	8,513,887,423.53
120	Нийтлэг татварын бус орлого	9,351,112,602.67	8,513,887,423.53
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,955,144,978.32	8,114,191,851.23
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,102,030,884.82	5,738,799,330.04
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,143,914,093.50	2,375,392,521.19
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Бараа материал	3,366,202,847.74	399,695,572.30
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	25,411,029,206.86	18,737,913,017.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	25,411,029,206.86	18,737,913,017.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,675,346,580.13	9,776,159,542.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,041,160,763.25	1,090,728,500.67
210101	Үндсэн цалин	806,872,214.54	1,090,728,500.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	149,475,154.12	150,316,434.79
210201	Тэтгэврийн даатгал	103,918,100.00	95,457,527.69
210202	Тэтгэмжийн даатгал	10,938,700.00	12,150,456.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,751,000.00	15,977,446.52
210204	Ажилгүйдлийн даатгал	2,187,700.00	2,430,091.22
210205	Эрүүл мэндийн даатгал	23,679,654.12	24,300,912.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	183,448,879.18	135,385,898.37
210301	Гэрэл, цахилгаан	119,227,030.33	99,581,316.79
210302	Түлш, халаалт	51,328,398.85	22,369,349.16
210303	Цэвэр, бохир ус	12,893,450.00	13,435,232.42
2104	Хангамж, бараа материалын зардал	1,486,834,603.73	206,810,226.41
210401	Бичиг хэрэг	34,101,510.00	40,864,704.00
210402	Тээвэр, шатахуун	48,425,682.00	46,700,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	28,648,399.92	35,595,527.41
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	1,808,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,651,760.00	8,088,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	67,897,450.00
210408	Бараа материал актальсны зардал	-	5,856,545.00
2105	Нормативт зардал	-	25,038,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	25,038,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,587,630.00	29,515,765.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,232,100.00	7,493,950.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00	959,500.00
210604	Урсгал засвар	22,355,530.00	21,062,315.00
2107	Томилолт, зочны зардал	84,705,625.13	70,999,301.00
210702	Дотоод албан томилолт	84,705,625.13	70,999,301.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,489,641,331.74	5,134,366,171.73
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,463,994,067.74	4,871,037,471.23
210803	Даатгалын үйлчилгээ	1,937,300.00	347,490.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,378,982.00	1,703,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	550,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,050,000.00	52,500,000.00
210807	Газрын төлбөр	13,730,982.00	208,733,710.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,208,492,592.98	2,932,999,244.27
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	484,202,912.44	13,253,192.81
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,724,289,680.54	2,919,746,051.46
211	ХҮҮ	16,665,766,551.73	8,939,427,600.39
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	16,665,766,551.73	8,939,427,600.39
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	16,665,766,551.73	8,939,427,600.39

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,916,075.00	22,325,875.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,916,075.00	22,325,875.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	69,916,075.00	22,325,875.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(16,056,316,604.19)	(10,224,025,594.10)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	1,547,907,714.95	2,272,291,269.44
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	782,303,516.09	89,199,064.18
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	765,604,198.86	2,183,092,205.26
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	10,386,352,691.77	12,324,434,339.98
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	10,386,352,691.77	6,690,581,812.34
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	5,224,508,358.74
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал Үндсэн хөрөнгө	-	197,882,200.67
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал Бараа материал	-	211,461,968.23
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(24,894,761,581.01)	(20,276,168,664.64)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	39,296,133,226.37	39,540,602,389.63
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	43,330,842,832.22	16,394,737,772.39
120	Нийтлэг татварын бус орлого	43,330,842,832.22	16,394,737,772.39
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	43,330,842,832.22	16,394,737,772.39
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	36,576,386,461.57	15,117,273,714.51
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,754,456,370.65	1,277,464,057.88
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	(4,034,709,605.85)	23,145,864,617.24
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	(4,034,709,605.85)	(3,423,185,703.42)
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	(4,038,309,605.85)	(3,423,185,703.42)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	26,569,050,320.66
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	26,140,169,030.01
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	428,881,290.65
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,982,866,859.04	41,866,622,231.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,982,866,859.04	41,866,622,231.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,737,909,125.79	41,830,382,231.52
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,720,733,476.74	41,830,382,231.52
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,695,086,212.74	41,830,382,231.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	244,957,733.25	36,240,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	175,041,658.25	36,240,000.00
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	175,041,658.25	36,240,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	34,313,266,367.33	(2,326,019,841.89)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(24,571,733,110.47)	3,423,185,703.42
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	24,571,733,110.47	(3,423,185,703.42)
230001	Эргэж төлөгдөх зээл	24,571,733,110.47	(3,423,185,703.42)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	2,391,680,264.74	1,097,165,861.53
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	86,084,931.30	2,477,765,196.04
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,477,765,196.04	3,574,931,057.57

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон**/төгрөгөөр/*

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,537,499,194.84	104,830,196,183.30
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(17,900,000.00)	(17,900,000.00)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,519,599,194.84	104,812,296,183.30
9	Тайлант үеийн үр дүн	(24,894,761,581.01)	(24,894,761,581.01)
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	(14,375,162,386.17)	79,917,534,602.29
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,225,263,540.56	2,225,263,540.56
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	(12,149,898,845.61)	82,142,798,142.85
19	Тайлант үеийн үр дүн	(20,276,168,664.64)	(20,276,168,664.64)
20	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	(32,426,067,510.25)	61,866,629,478.21

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	48,036,778,300.00	3,423,185,703.42	44,613,592,596.58	7.1
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	48,036,778,300.00	3,423,185,703.42	44,613,592,596.58	7.1
230001	Эргэж төлөгдөх зээл	48,036,778,300.00	3,423,185,703.42	44,613,592,596.58	7.1
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	48,036,778,300.00	3,423,185,703.42	44,613,592,596.58	7.1
37	БУСАД ЭХ ҮҮСВЭР	48,036,778,300.00	3,423,185,703.42	44,613,592,596.58	7.1
370001	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	48,036,778,300.00	3,423,185,703.42	44,613,592,596.58	7.1

Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлагдсан төсөв

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	57,833,308,862.50	46,744,037,219.17	11,089,271,643.30	80.8
УРСГАЛ ЗАРДАЛ	5,910,613,262.50	5,950,707,367.84	-40,094,105.30	100.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,878,113,262.50	5,928,381,492.80	-50,268,230.30	100.9
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,232,493,300.00	1,232,493,300.00	-	100
Үндсэн цалин	1,040,829,300.00	1,040,829,300.00	-	100
Унаа хоолны хөнгөлөлт	191,664,000.00	191,664,000.00	-	100
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	154,061,662.50	154,061,700.00	-37.5	100
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	127,140,000.00	124,902,186.34	2,237,813.70	98.2
Гэрэл, цахилгаан	89,331,900.00	89,097,604.77	234,295.20	99.7
Түлш, халаалт	23,070,600.00	22,369,349.16	701,250.80	97
Цэвэр, бохир ус	14,737,500.00	13,435,232.41	1,302,267.60	91.2
Хангамж, бараа материалын зардал	106,434,700.00	103,658,900.00	2,775,800.00	97.4
Бичиг хэрэг	16,875,000.00	16,875,000.00	-	100
Тээвэр, шатахуун	39,975,800.00	39,000,000.00	975,800.00	97.6
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	35,958,000.00	34,158,000.00	1,800,000.00	95
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,283,400.00	4,283,400.00	-	100
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,342,500.00	9,342,500.00	-	100
Эд хогшил, урсгал засварын зардал	159,738,000.00	156,003,015.00	3,734,985.00	97.7
Багаж, техник, хэрэгсэл	31,200,000.00	30,132,450.00	1,067,550.00	96.6
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,957,400.00	4,900,000.00	57,400.00	98.8
Урсгал засвар	123,580,600.00	120,970,565.00	2,610,035.00	97.9
Нормын хувцас	20,000,000.00	19,795,000.00	205,000.00	99
Нормын хувцас	20,000,000.00	19,795,000.00	205,000.00	99
Томиллолт, зочны зардал	74,416,400.00	74,214,091.00	202,309.00	99.7
Дотоод албан томилолт	74,416,400.00	74,214,091.00	202,309.00	99.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,003,829,200.00	4,063,253,300.50	-59,424,100.50	101.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,815,924,600.00	3,815,924,600.00	-	100
Лифтний засвар, баталгаажуулалт	40,000,000.00	347,490.00	39,652,510.00	0.9
Салбаруудын төсөв	1,700,000,000.00	1,703,500.00	1,698,296,500.00	0.1
Силос, од, бункерийн ариутгал	100,000,000.00	44,000.00	99,956,000.00	0
Пүү, лабораторийн багаж баталгаажуулах	40,000,000.00	36,500,000.00	3,500,000.00	91.3
Элеваторийн өвчин хортон ариутгал	5,000,000.00	208,733,710.50	-203,733,710.50	4,174.70
Элеваторийн их засвар	500,000,000.00	-	500,000,000.00	-
Үр, хүнсний будаа, гурилын шинжилгээ	35,000,000.00	-	35,000,000.00	-
Харуул, хамгаалалт гэрээт	166,000,000.00	-	166,000,000.00	-
ГАУС сэргийлэлт	15,000,000.00	-	15,000,000.00	-
Хатаалгын шатахуун	500,000,000.00	-	500,000,000.00	-
Төмөр зам арчлалтын хөлс	74,000,000.00	-	74,000,000.00	-
Вагон таталт, тавилт	40,000,000.00	-	40,000,000.00	-
Туслах үйл ажиллагааны зардал	420,924,600.00	-	420,924,600.00	-
Судалгаа, шинжилгээ	50,000,000.00	-	50,000,000.00	-
Өр барагдуулах ажлын гэрээ	70,000,000.00	-	70,000,000.00	-
Аудит болон бусад үйлчилгээ	60,000,000.00	-	60,000,000.00	-
Төлбөр хураамж	187,904,600.00	247,328,700.50	-59,424,100.50	131.6
Даатгалын үйлчилгээ	1,937,300.00	347,490.00	1,589,810.00	17.9
Тээврийн хэрэгслийн татвар	1,787,500.00	1,747,500.00	40,000.00	97.8

Мэдээллийн технологийн үйлчилгээ	50,000,000.00	36,500,000.00	13,500,000.00	73
Газрын төлбөр	134,179,800.00	208,733,710.50	-74,553,910.50	155.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,500,000.00	22,325,875.00	10,174,125.00	68.7
Бусад урсгал шилжүүлэг	32,500,000.00	22,325,875.00	10,174,125.00	68.7
Нэг удаагийн тэтгэмж	32,500,000.00	22,325,875.00	10,174,125.00	68.7
Дэмжлэгийн төлбөр	21,119,354,600.00	11,181,787,378.43	9,937,567,221.60	52.9
Газар тариалангийн үйлдвэрлэлийн дэмжлэг	21,119,354,600.00	11,181,787,378.43	9,937,567,221.60	52.9
Стратегийн нөөц бүрдүүлэлт	30,000,800,000.00	29,611,542,472.90	389,257,527.10	98.7
Хүнсний буудай	21,000,000,000.00	20,558,488,516.60	441,511,483.40	97.9
Үрийн буудай	9,000,800,000.00	9,053,053,956.30	-52,253,956.30	100.6
Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, худалдаа	802,541,000.00	-	802,541,000.00	-
Хамгаалагдсан хөрсний тариалан эрхлэхэд дэмжлэг үзүүлэх	375,001,000.00	-	375,001,000.00	-
Жимс, жимсгэнийн тариалан эрхлэхэд дэмжлэг үзүүлэх	427,540,000.00	-	427,540,000.00	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	57,833,308,862.50	47,841,203,080.70	9,992,105,781.80	82.7
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	57,833,308,862.50	47,841,203,080.70	9,992,105,781.80	82.7
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	46,335,268,262.50	46,335,268,300.00	-37.5	100
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,498,040,600.00	1,505,934,780.70	9,992,105,819.30	13.1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2,477,765,196.04		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		3,574,931,055.57		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		26,569,050,320.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ		26,569,050,320.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		26,569,050,320.66
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		26,569,050,320.66
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		26,569,050,320.66
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		26,569,050,320.66
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		26,569,050,320.66
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		26,140,169,030.01
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		428,881,290.65

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 388,232.5 сая төгрөгийн 18 алдаа, зөрчил илэрснээс 18,278.8 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 4 алдаа илэрснийг аудитын явцад залруулж, 369,873.0 сая төгрөгийн зөрчилд 10 албан шаардлага, 1 хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлж, 80.7 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Аудитаар нийт 18,278.8 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 4 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

- Авлага дансны үлдэгдэлд 383 харилцагчийн 15,735.8 сая төгрөгийн илүү төлөлтийн буруу ангилалд хийсэн бичилтийг авлагын дансанд;
- Гадаад дамжуулан зээл авсан 78 иргэн, хуулийн этгээдийн 2,283.9 сая төгрөгийн ханшийн тэгшитгэлийг авлага, гадаад валютын ханшийн зөрүүний олз дансанд;
- Шилжүүлэн өгсөн 217.2 сая төгрөгийг авлага данснаас үнэ төлбөргүй шилжиж ирсэн хөрөнгө дансанд;
- Нөөцийн бараа дансанд давхар орлого авсан 41.9 сая төгрөгийг авлагын дансанд тус тус залруулсан байна.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Авлага дансны үлдэгдэлд 383 харилцагчийн 15,735.8 сая төгрөгийн илүү төлөлтийн буруу ангилалд бүртгэсэн	1	15,735,829.1			1	15,735,829.1	1	15,735,829.1		
Гадаад дамжуулан зээл авсан 78 иргэн, хуулийн этгээдийн 2,283.9 сая төгрөгийн ханшийн тэгшитгэл хийгээгүй	1	2,283,958.1	1	2,283,958.1			1	2,283,958.1		
Балансаас балансад шилжүүлэн өгсөн хөрөнгийг 217.2 сая төгрөгийн авлага үүсгэж бүртгэсэн	1	217,205.0			1	217,205.0	1	217,205.0		
Нөөцийн бараа дансанд 41.9 сая төгрөгийн давхар орлого авч бүртгэсэн	1	41,984.0			1	41,984.0	1	41,984.0		
Дүн	4	18,278,976.2	1	2,283,958.1	3	15,995,018.1	4	18,278,976.2		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Нийт авлагын дүнгийн 81.5 хувь буюу 9,888 харилцагчийн 179,257,239.1 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй.	1	179,257,239.1			1	179,257,239.1				
Тайлант онд олгосон дэмжлэгийн зээлийг түүвэрлэн шалгахад БНХАУ-ын эх үүсвэртэй усалгааны тоног төхөөрөмжийн зээлийг иргэн, хуулийн этгээдэд олгохдоо гэрээнд заасан	1	3,445,354.0			1	3,445,354.0				

барьцааны шаардлага хангахгүй 16 иргэн, хуулийн этгээдэд 3,445,354.0 мянган төгрөгийн зээл олгосон. Мөн гадаад зээлийн эх үүсвэрийг иргэн, хуулийн этгээдэд зээлдүүлэх гэрээ хийхдээ зээлийн барьцаанд бүртгэж буй хөрөнгийг мэргэшсэн үнэлгээчнээр үнэлүүлээгүй, эрсдэлийн үнэлгээ хийхдээ төслүүдийн эдийн засгийн үр ашиг, төлбөрийн чадварын талаар дүгнэлт хийдэггүй.									
Засгийн газрын 2021 оны "Төрийн өмчит компани байгуулах тухай" 394 дүгээр тогтоолыг үндэслэн Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК статустай болгохоор шийдвэрлэсэн гэсэн шалтгаанаар 2022 оны төсвийг батлаагүй, үйл ажиллагааны зардлыг баталсан төсөвгүйгээр 15,261,331.9 мянган төгрөгийн арилжааны банкна дахь харилцах данснаас төсвөөс гадуур зарцуулсан. Эргэн төлөлдөх цэвэр 44,613,592.6 мянган төгрөг 7.1 хувийн гүйцэтгэлтэй байна.	1	59,874,924.5			1	59,874,924.5			
Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Хөгжлийн банкны Ди Би Эм Лизинг ХХК хооронд 2017-2019 онд байгуулсан санхүүгийн түрээсийн 4 гэрээгээр 10.0 сая ам.доллар, 8.3 сая еврогийн өртөгтэй 835 тоног төхөөрөмж авсан зээлийн эргэн төлөлтийг хийгээгүй, жил бүрийн төсөвт тусгаагүй, харилцагчдаас орсон дамжуулан зээлийг төлбөрийг үйл ажиллагааны зардалд зарцуулснаас нийт 52,712,030.3 мянган төгрөгийн дамжуулан зээлийн хугацаа хэтэрсэн өртэй.	1	52,712,030.3			1	52,712,030.3			
Өмнөх онуудад худалдан авч бэлтгэсэн, зах зээлд борлогдохгүй, хадгалах хугацаа дууссан, 312,543.5 мянган төгрөгийн 11 нэр төрлийн их хэмжээний бараа материалын үлдэгдэлтэй.	1	312,543.5			1	312,543.5			
Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлийн хугацаа дууссан 5,724,232.1 мянган төгрөгийн хөрөнгө байна.	1	5,724,232.1			1	5,724,232.1			
Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан "2020-2021 оны санхүүгийн бүртгэл сайжруулах" аудитын 3 хуулийн этгээдтэй хийсэн 59,800.0 мянган төгрөгийн гэрээнд заасан ажлын даалгавар бүрээр гэрээт ажлын гүйцэтгэлийг үнэлээгүй, гэрээ дүгнэсэн акт үйлдэж ажиллаагүй	1	59,800.0			1	59,800.0			
Хөдөө аж ахуйг дэмжих сангийн хэрэгжүүлэх хөтөлбөрт тусгагдаагүй арга хэмжээнд 80,754.8 мянган төгрөгийг зарцуулсан.	1	80,754.8					1	80,754.8	
Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж 260,539.2 мянган төгрөгийн тариаланчдын нэгдсэн зөвлөгөөний хурлын ажлыг зохион байгуулсан байна.	1	260,539.2			1	260,539.2			
Хөдөө аж ахуйг дэмжин сангийн 315 харилцагчийн 67,875,066.3 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй.	1	67,875,066.3			1	67,875,066.3			
Тайлант онд 180,470.3 мянган төгрөгийн төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй, элеваторын сэлбэг засварын	1	351,290.0			1	351,290.0			

материал худалдан авах, Дархан салбарын засварын ажилд 170,819.7 мянган төгрөгийн 27 шууд гэрээ байгуулан тендер зохион байгуулаагүй.										
Хөдөө, аж ахуйг дэмжин сангийн Хөдөө, аж ахуйн үйлдвэрийн газар дамжуулан зээлийн хөрөнгийг эцсийн зээлдэгчид зээлдүүлэх, түрээслүүлэх гэрээ байгуулах ажлыг зохион байгуулдаг боловч зээлдэгчийн хувийн хэрэг, зээлийн дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй. Мөн Санхүү, бүртгэлийн хэлтэс нь санхүүгийн тайланд зээлийн авлагыг бүртгэж, тайлагнахдаа зээлийн гэрээнд заасан хүү, хугацаа хэтэрсэн алдангийг тооцож бүртгэлд тусгаж, тайлагнахгүй байгаа нь газар нэгжүүдийн чиг үүргийн хуваарилалт оновчгүй байгаатай холбоотой байна.	1	-					1	-		
Сангийн хүний нөөцийн тогтворжилтын түвшингийн судалгаагаар тайлант онд 52 ажилтан ажлаас гарч, 50 ажилтан шинээр ажилд орсон байгаа нь ажилтнуудыг тогтвортой ажиллуулах бодлого алдагдсан байна. Дээрх хүний нөөцийн хөдөлгөөний үед 20 ажилтны тойрох хуудас зуруулж, үндсэн хөрөнгө болон ажил хүлээлцсэн акт үйлдээгүй, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтад тавих дотоод хяналт сул байна.	1	-					1	-		
Өмнөх оны аудитаар тогтоосон төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитаар "Сөрөг дүгнэлт" авсан.	1	-							1	-
Дүн	14	369,953,773.8	-	-	10	369,873,019.0	3	80,754.8	1	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд 60 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.	1	-			1	-		
Дүн								
Нийт дүн	1	-	-	-	1	-	-	-